

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/128/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он</p>	<p>Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Санжаажав Утас: 70373089 Цахим хаяг: Sanjaajavs@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.ГАНЗОРИГ ТАНАА

2022.07.25 № 124
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Д.МӨНХБАЯР/



009020118

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>359,543,288.86</u>	<u>392,942,779.72</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>6,474,477,747.99</u>	<u>5,616,265,417.33</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>6,834,021,036.85</u>	<u>6,009,208,197.05</u>
	Нийт өр төлбөрийн дүн	-	251,633.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>6,834,021,036.85</u>	<u>6,008,956,564.05</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>6,834,021,036.85</u>	<u>6,009,208,197.05</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,589,901,677.43	4,266,148,180.06
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,742,807,460.84	4,984,730,371.94
	Үйл ажиллагааны үр дүн	<u>(152,905,783.41)</u>	<u>(718,582,191.88)</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(60,486,680.08)	(138,482,280.92)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>7,047,413,500.34</u>	<u>7,047,413,500.34</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,047,413,500.34	6,885,390,399.01
	Тайлант оны үр дүн	6,834,021,036.85	(857,064,472.80)
	Эцсийн үлдэгдэл	<u>6,834,021,036.85</u>	<u>6,008,956,564.05</u>
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>3,882,693,309.00</u>	<u>4,064,230,409.30</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>3,878,575,309.00</u>	<u>4,057,230,409.30</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>4,118,000.00</u>	<u>7,000,000.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>4,118,000.00</u>	<u>7,000,000.00</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	<u>3,959,618,300.00</u>	<u>3,955,525,586.20</u>
	Урсгал зардал	3,959,618,300.00	3,955,525,586.20
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	<u>3,959,618,300.00</u>	<u>3,955,525,586.20</u>
	Улсын төсвөөс санхүүжих	3,882,605,200.00	3,871,664,276.90
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	<u>77,013,100.00</u>	<u>83,861,309.30</u>

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцэж байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,963,962.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

7.1 Залруулсан алдаа

Аудитаар илэрсэн алдаанд дараах залруулгыг хийлгэсэн болно.

- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүнг 1,773,016.8 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг 145,402.1 мянга, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг 41,329.1 мянга, нийт 186,731.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн дансанд 411.8 мянган төгрөгийн хасах үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэсэн мөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн санхүүгийн байдлын тайлантай 3,802.2 мянган төгрөгийн зөрүүтэй.

7.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

7.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

7.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

